




МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
NATIONAL STATISTICAL OFFICE OF MONGOLIA

СТАТИСТИКИЙН БЮЛЛЕТЕНЬ BULLETIN OF STATISTICS



2010/02

ГАРЧИГ CONTENTS

Ерөнхий тэмдэглэл <i>General notes</i>	3
Аргачлалын тайлбар <i>Methodological notes</i>	4
Товч танилцуулга <i>Introduction</i>	10
Үндсэн үзүүлэлтүүд <i>Main indicators</i>	19
I. Хөдөлмөр <i>Labour</i>	20
II. Өрхийн орлого, зарлагын судалгаа <i>Household income and expenditure</i>	31
III. Нийгмийн даатгал, нийгмийн халамж <i>Social insurance and social welfare</i>	35
IV. Эрүүл мэнд <i>Health</i>	37
V. Гэмт хэрэг <i>Crime</i>	40
VI. Үнэ <i>Prices</i>	44
VII. Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл <i>Money, loan, stock market</i>	54
VIII. Улсын төсөв <i>State budget</i>	61
IX. Төлбөрийн тэнцэл <i>Balance of payments</i>	63
X. Гадаад худалдаа <i>External trade</i>	65
XI. Хөдөө аж ахуй <i>Agriculture</i>	77
XII. Аж үйлдвэр <i>Industry</i>	79
XIII. Их барилга <i>Construction</i>	84
XIV. Тээвэр <i>Transport</i>	85
XV. Цаг уур, агаарын бохирдолт <i>Meteorology and air pollution</i>	86
Хавсралт <i>Appendix</i>	88

Ерөнхий тэмдэглэл**General notes****I. Товчилсон тэмдэглэгээ:**

АР	Архангай
БӨ	Баян-Өлгий
БХ	Баянхонгор
БУ	Булган
ГО	Говь-Алтай
ДО	Дорноговь
ДД	Дорнод
ДУ	Дундговь
ЗА	Завхан
ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
ТӨ	Төв
УВ	Увс
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
ДА	Дархан-Уул
УБ	Улаанбаатар
ОР	Орхон
ГС	Говьсүмбэр

I. Abbreviations:

AR	Arkhangai
BO	Bayan-Olgii
BKH	Bayankhongor
BU	Bulgan
GO	Govi-Altai
DO	Dornogovi
DD	Dornod
DU	Dundgovi
ZA	Zavkhan
OV	Ovorkhangai
OM	Omnogovi
SU	Sukhbaatar
SE	Selenge
TO	Tov
UV	Uvs
KHO	Khovd
KHS	Khovsgol
KHE	Khentii
DA	Darkhan-Uul
UB	Ulaanbaatar
OR	Orkhon
GS	Govisumber

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V... г.м)

I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.

1990-1995; 1990-1997 тухайн хугацааны жилийн дундаж үзүүлэлт болно.

III. Дараах тэмдэглэлүүдийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй.

II. Months have been shown by the Roman numerals (I, II, III, IV, V, etc).

I-XII shows the accumulated data from the beginning of the year including the particular month.

1990-1995; 1990-1997 annual average for this particular time period.

III. The following symbols were used:

... data are not available

0.0 the amount is nil or negligible

- no execution.

⌌ “Үүнээс” гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

⌌ Shows the term “of which” and in some cases it indicates not all elements of sum are given.

IV. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

IV. Due to the rounding figures (composition) may not add up to the total and 100 percentage.

Аргачлалын тайлбар**Ажиллах хүчний судалгаа**

Үндэсний тооцооны системийн хүрээнд “Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)”-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна. Эдийн засгийн идэвхтэй хүн амыг эдийн засгийн байнгын идэвхтэй, тухайн үеийн идэвхтэй хүн ам гэж хоёр ангилна.

Эдийн засгийн байнгын идэвхтэй хүн амд урт хугацаагаар буюу сүүлийн 12 сарын хугацаанд ажил эрхэлж байсан болон ажилгүй байсан хөдөлмөрийн насны хүн амыг хамруулна.

Эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн амд сүүлийн 7 хоногт ажил эрхэлж байсан болон ажилгүй байсан иргэдийг хамруулна.

Эдийн засгийн тухайн үеийн идэвхгүй хүн ам гэж сүүлийн 7 хоногт сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон болон өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллагч болон ажилгүй иргэдийн алинд ч хамаарахгүй хүмүүсийг хэлнэ.

Ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхэлж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон ажиллагчид хамрагдана.

Ажилгүй иргэнд тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай хүмүүсийг хамруулна.

а/ “ажилгүй байсан” гэж сүүлийн долоо хоногт Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр болон ажил гүйцэтгэх гэрээгээр ямар нэг ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхэлж орлого олоогүй байхыг;

б/ “ажил хийхэд бэлэн” гэж Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас татгалзахгүй байхыг;

в/ “ажил идэвхтэй хайж байгаа” гэж ажилд зуучлах төрийн болон хувийн

Methodological notes**Labour force survey**

The economically active population (Labour Force) comprising all persons of either sex who furnish the supply of labour for the production of economic goods and services (employed and unemployed, including those seeking work), as defined by the System of National Accounts (SNA), during a specified time reference period. Economically active population is divided into "usually active" or "currently active" during a specified time-reference period.

The usually active population comprises all persons a specified working age whose activity status, as determined in terms of the total number of weeks or days during a long specified period or the preceding 12 months or the preceding calendar year was either employed or unemployed.

Economically currently active population comprises of population of labour age, unemployed or employed in terms of their primary activity for the last week.

The economically currently inactive population comprises all persons who were neither "employed" or "unemployed" during the last week for the reasons such as attendant at educational institutions; retired; engaged in family duties and disabled.

Employed means all citizen engaged in economic activity for pay (wages or salary) and having an employment status of some sort. One can be regarded as employed if engaged in economic activity for pay above an hour for the last week.

Unemployed is a citizen of labour age, with full work abilities, who was for a while unemployed, ready to work and actively looking for a job.

a/ not employed means no work has been done for pay or by an employment contract, no income was earned as self-employed work or services within last week, as stated in Law on Labour or Clause 359 of Civil code.

b/ "available for work" means to be not against signing an employment contract or a work agreement as stipulated in Law on Labour or Clause 359 of Civil code.

c/ "actively seeking a job" means

байгууллагад бүртгүүлж, нэгээс доошгүй удаа ажлын байрны талаар мэдээлэл авсан эсхүл ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих зэргээр ажил олох оролдлого идэвхтэй хийснийг тус тус ойлгоно.

actively trying to get a job by registering with state or private employment offices, having information about vacancies at least once, or addressed at least once to job vacancies provider or their internet pages, placing job seeking advertisements in posters, and mass media.

Хөдөлмөр

Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-д Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ыг эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам гэж хоёр ангилна.

Ажилгүй иргэнд тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хамруулна.

Labour

The economically active population (Labor Force) comprising all persons of either sex who furnish the supply of labour for the production of economic goods and services (employed and unemployed, including those seeking work), as defined by the System of National Accounts (SNA), during a specified time reference period. Economically active population is divided into "usually active" or "currently active" during a specified time-reference period.

Unemployed is a citizen of labour age, with full work abilities, who was for a while unemployed, ready to work and actively looking for a job.

Өрхийн орлого, зарлага

Үндэсний статистикийн байгууллага 1966 оноос эхлэн өрхийн орлого, зарлагын судалгааг явуулж байгаа бөгөөд одоогийн байдлаар жилд Монгол Улсын нийт өрхийг төлөөлөх 11232 өрхийг түүвэрлэн авч, тэдгээр өрхийн гишүүдийн нас, хүйс, ажил эрхлэлтийн байдал, өрхийн орлого, зарлага, хэрэглээний хэмжээ, сууцны нөхцлийн талаарх үзүүлэлтүүдийг хамруулан улирал бүр судалгаа явуулж байна.

Хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын үзүүлэлтүүдийг тооцох зорилгоор уг судалгааны арга зүйг (түүвэрлэлтийн зохиомж, судалгааны асуулгын үзүүлэлтүүд, загвар) 2005 оны 3 дугаар улирлаас эхлэн өөрчилсөн. Мөн өрхийн хэрэглээ, зардлын нэр төрлийг өргөжүүлэн олон улсын аргачлалаар "Хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангилал"-ын дагуу бүлэглэн бүртгэдэг болсон.

Нэг өрхийн сарын дундаж орлого, зарлагыг 2007 оны III улирлаас эхлэн Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүнгийн мэдээлэлд тулгуурлан тооцдог болсон тул аргачлал нь өмнөх судалгааныхаас өөрчлөгдсөн болно.

Household income and expenditure

Since 1966, the National Statistical Office has regularly conducted household income and expenditure survey. At present, a sample of 11232 households was selected annually to represent the total households of Mongolia and data on household member's age, sex, employment, household income, expenditure, consumption and housing condition are collected and analyzed on a quarterly bases.

The survey methodology (sample, questionnaire design and indicators) has been changed since the 3rd quarter of 2005 for estimating living standard and poverty indicators. Moreover the type of household consumption and expenditure was collected in accordance with international methodology as "COICOP".

Since 3rd quarter of the year 2007, we have estimating average monthly income and expenditure of the household from result of Household socio-economic survey, hence its methodology had changed.

Нийгмийн даатгал, нийгмийн халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ мөн. Нийгмийн даатгал нь тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс бүрдэнэ.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг “нийгмийн халамж” гэнэ.

Нийгмийн даатгал, халамжийн мэдээг 2009 оны 4-дүгээр сараас эхлэн сар бүр гаргаж байна.

Эрүүл мэнд

Эрүүл мэндийн сарын мэдээг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар аймаг нийслэлийн харъяа нэгжүүдээсээ авч нэгтгэн Үндэсний статистикийн хороонд (ҮСХ)-нд ирүүлдэг.

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд ногдох), 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд ногдох), халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, өвчний ангиллаар, эмчлүүлсэн болон нас барсан хүний тоог бүсээр гаргаж тооцож оруулсан болно.

Нялхсын эндэгдэл (1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох)-ыг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох)-ыг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Гэмт хэрэг

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг

Social insurance and social welfare

The social insurance is a socio-economic measure to provide pensions, benefits or payments prescribed in the legislation to the insured person in contingencies of retirement, disability, sickness and unemployment, as well as his/ or her dependents in case of the insured person's death, having established a Social Insurance Fund through contributions payable by individuals. The social insurance shall consist of the branches as 1/ pension insurance, 2/ benefits insurance, 3/ health insurance, 4/ insurance against employment injury and occupational diseases, 5/ unemployment insurance.

The social welfare is a measure to provide pensions, conditioned cash benefits and community based welfare and specialized care or nursing prescribed in the legislation to the person who needs social welfare supports.

Data on social insurance and welfare is published monthly basis starting from April 2009.

Health

Monthly health statistics are compiled through local units of Health Department, an Implementing Agency of the Government of Mongolia and received by the NSO of Mongolia.

The mortality rate /infant mortality rate/ among children up to 1 year old in every 1000 live birth, child mortality rate aged between 1-5 years old in every 1000 live births, a number of people infected by contagious disease, a classification of diseases, and a number of cured people and deaths are calculated by regions.

The infant mortality rate (infants under age one year per 1000 live births) is estimated as a ratio of the number of deaths of infants under 1 year to the number of alive births during a particular period of time.

The under 1-5 mortality rate (under 1-5 age one year per 1000 live births) is estimated as a ratio of the number of deaths of under 1-5 year to the number of alive births during a particular period time.

Crime

Culpable acts and omissions subject to the criminal liability specified in the Criminal Code which are socially dangerous

гэнэ. Гэмт хэргийн мэдээллийн эх үүсвэр Цагдаагийн ерөнхий газрын сар бүрийн мэдээ юм.

Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нэлээд өөрчлөгдсөн.

-Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.

-Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

-Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.

-Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

-Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.

shall be recognized crimes. Crime data source is monthly report of General Police Department.

Crimes shall be classified as follows according to the nature and degree of their social danger and gravity of the punishment to be imposed minor, less serious, serious and grave.

The Crime indicators have been innovated and enriched in connection with change of Criminal Law.

- Indicators like crime against human life, health, crime to cause others to commit suicide, violent crime such as attempted and negligent murder are being compiled in the bulletin;

- Rape crime was included to the crime against children, family and social morality;

- Crime against ownership right includes theft of property, robbery, snatch away others property, deceiving to obtain others property, illegally misuse others property and wasting;

- Arson was included to crime against environmental protection.

- Indecent assault was added to crime against social safety.

The number of committed offences per 10000 population aged 18 and over is a quotient of the number of crimes and number of people aged 18 and over at the beginning of the year.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2005 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

Аймгийн төв, нийслэлийн захуудад борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай

Prices

The consumer price index is a weighted average by consumption expenditure distribution of prices of various goods and services purchased by the households for its own consumption.

Since January 2008 having revised its methodology for CPI by which CPI for Ulaanbaatar city was taken a national CPI, the National Statistics Committee has moved to the international methodology by which the national CPI is estimated on the basis of weighted average for 2005 HIES consumption expenditure of aimags and the Capital city.

The average market prices of agricultural foodstuff, wool, hide & skin at

хүнсний бүтээгдэхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөнд банкнаас гадуурх мөнгө, банкны касс дахь бэлэн мөнгийг оруулна.

Мөнгө M1-д улсын болон хувийн секторын харилцах дансан дахь мөнгө, иргэдийн хугацаагүй хадгаламж, банкны гадуурх бэлэн мөнгийг хамруулна.

Мөнгө M2 бол Мөнгө M1 болон бараг мөнгөний нийлбэр юм. Бараг мөнгөнд иргэд, байгууллагуудын хугацаатай хадгаламжууд, гадаад валютын хадгаламжийг хамруулна.

Үнэт цаасны тухайн сарын арилжаанд хамгийн их гүйлгээтэй байсан компанийн хувьцааг идэвхтэй хувьцаа гэж үздэг.

Монгол Улсын нэгдсэн төсөв

Төсвийн орлого, зарлагын тооцоог Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төсвийн болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Сангийн яам, аймаг, нийслэлийн харъяа нэгжүүдээсээ авч нэгтгэн Үндэсний Статистикийн хороо (ҮСХ)-нд ирүүлдэг.

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын дүнд Засгийн газрын тусгай зориулалтын гэж нэрлэдэг Тэтгэврийн, Нийгмийн халамжийн, Замын, Өмч хувьчлалын сангуудын орлого, зарлагыг оруулсан.

Гадаад худалдаа

ҮСХ-ны дарга, Сангийн сайд, Гаалийн Ерөнхий Газрын даргын 2009 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хамтарсан тушаалаар "Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал"-ыг шинэчлэн баталж мөрдүүлсэн. Шинэчлэгдсэн аргачлалын дагуу гадаад худалдааны барааны статистикийн мэдээллийг тооцож байна. Мөн өмнөх оны гүйцэтгэлүүдийг шинэчилсэн аргачлалын дагуу тооцлоо.

aimags centers & the capital city were shown.

Money, loan, stock market

Currency in circulation includes the population and commercial banks cash and currency outside the banks.

Money M1 includes public and private sector's bank account currency, population demand deposits and currency outside the banks.

Money M2 is a sum of money M1 and Quasi money. Quasi money consists of the time saving deposits of individuals and enterprises as well as foreign currency deposits.

An active stock in a particular month is considered as the stock of companies with predominated trading.

General government budget

Since October 1995, the budget revenue and expenditure has been compiled according to the International Monetary Fund standard classifications.

The Mongolian General government budget revenue and expenditure consists of the central and local budget revenue and expenditure.

The Ministry of Finance collect and aggregate the General government budget revenue and expenditure data from it's department and offices that are under the jurisdiction of the ministry and forward the data to the National Statistical Office (NSO).

State budget revenue and expenditure includes revenue and expenditure of Government Special funds for Pension, Social Security, Roads, and Privatization.

External trade

On 17th February of 2009, the chairman of NSO, the Minister of Finance and the director of Customs General Administration approved "Methodology of calculating indicators of merchandise trade statistics". According to this new methodology and its amendments, estimates of previous years have changed.

Монгол Улсын Гаалийн Ерөнхий газрын статистикийн мэдээг үндэслэн тус бүлгийн хүснэгтүүдийг боловсруулав.

Дэлхийн худалдааны байгууллагаас боловсруулсан “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн ангиллын дагуу барааны бүлэг, нэр төрлийг авсан болно. С.И.Ф нөхцлийн үнээр импортын барааг үнэлэх бөгөөд энэ нь худалдан авагч орны хил хүртэлх тээвэр болон даатгалын, гаалийн хураамж зэрэг зардлуудыг экспортлогч хариуцна гэсэн үг.

The table of this chapter were developed on the basis of the statistical reports from the Customs General Administration of Mongolia.

The commodities were classified according to the Harmonized System developed by the World Trade Organization. The price of import goods is defined by the CIF condition which means that exporter has to bear costs of transportation and insurance till purchaser's country border as well as customs tax.

Аж үйлдвэр

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Industry

Classification by the kind of economic activities is based on the ISIC (International Standard Industrial Classification) of United Nation.

The value of total industrial sale is value of sales, completed work and services of business entities during the particular period.

The growth of the industrial production was estimated on the basis of constant price of 2005 for the main commodities.

Data on production of the main industrial commodities shows a physical quantity of the particular produced goods.

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол, гамшгийн хувьд “Гамшгаас хамгаалах тухай” Монгол улсын хуульд заасан ойлголт, тодорхойлолтыг баримталж байна.

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно.

Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Hazardous phenomena and disasters

For terms, namely hazardous phenomena, disasters, and accidents, concepts and definitions set out in the Law on Disaster Protection of Mongolia are followed.

Disasters mean loss of many human lives and livestock, immense damage to property and environment that exceeds national and local resources and capacity due to hazardous phenomena, major technological accidents, and terrorist acts or explosion.

Hazardous phenomena mean severe snow, dust storm, drought, dzud, flood, earthquake, desertification, fire, epidemic, epizootic, hazardous vegetative diseases or spreading detrimental rodents.

Major technological accidents mean destruction of factories, buildings, communication or roads, accidents of transportation facilities or leakage of radioactive and hazardous chemical substances caused by violation of technological procedures.

**Монгол улсын нийгэм,
эдийн засгийн байдал**
(2010 оны эхний 2 сарын байдлаар)

**Socio-economic situation
of Mongolia**
(As of the first two months of 2010)

I. Нийгмийн үзүүлэлт

Монгол Улсад “Ажиллах хүчний түүвэр судалгаа(АХС)”-г 2002-2003 онд анх удаа олон улсын нийтлэг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон билээ. Харин “Статистикийн тухай” Монгол Улсын хуулинд 2004 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 2006 оноос АХС-г улирлаар явуулж, үр дүнг нэгтгэн тархаадаг болсон юм. ҮСХ-ны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 01/68/94 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ын дагуу 2009 оны 4 дүгээр улирлын судалгааг явууллаа.

2009 оны ажиллах хүчний 4-р улирлын судалгаанд сонгогдсон 3204 өрх 100 хувь хамрагдлаа.

Судалгааны дүнгээр 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 1120.3 мянга байгаагийн 596.1 мянга буюу 53.2 хувь нь эрэгтэй, 524.2 мянга буюу 46.8 хувь нь эмэгтэйчүүд байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын 977.4 мянга нь ажиллагчид, 142.9 мянга нь ажилгүй иргэд байна.

Ажилгүйдлийн түвшин 2009 оны 4-р улиралд улсын хэмжээнд 12.8 хувь, хотод 16.5 хувь, хөдөөд 7.9 хувьтай байна.

Аймаг, нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс (ХХҮХ)-т бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2010 оны 2 дугаар сарын эцсийн байдлаар 36.0 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 3728 хүнээр буюу 11.6 хувиар нэмэгдсэн байна.

Улсын хэмжээгээр 19.5 мянган эмэгтэй ажилгүй гэж бүртгүүлсэн нь нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 54.3 хувийг эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдээс 2010 оны эхний 2 сарын байдлаар 3.0 мян.хүн ажилд орсны 18.1 хувь нь төрийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллагад, 81.9 хувь нь компани, хоршоо, бусад байгууллагад ажилд оржээ.

I. Social indicators

Mongolia was conducted “Labor Force Survey (LFS)” on quarterly basis in accordance with the international common methodologies for the first time in 2002-2003 and it became a nationwide employment baseline survey that focused on seasonally adjustment in the labor market. Then according to amendments of the Law on Statistics of Mongolia in 2004, since 2006 NSO conducts LFS on quarterly basis and disseminates its results regularly. NSO conducted LFS of 4th quarter, 2009 according to the “Methodology on measuring employment and labor force statistics” approved by 01/68/94 joint order of the Chairman of NSO and Minister of Social welfare and labor in 2009.

The 3204 households sampled for LFS of 4th quarter, 2009 and its response rate was 100 per cent.

By the survey results, total number of economically active population aged 15 and above estimated at 1120.3 thousands which consists of 596.1 thousand persons or 53.2 per cent were males and 524.2 thousands or 46.8 per cent were females.

Of total economically active persons, 977.4 thousands were employees and 142.9 thousands are unemployed ones.

In 4th quarter, 2009, unemployment rates are 12.8 per cent at the national level, and 16.5 per cent in urban and 7.9 per cent in rural respectively.

As of the end of February 2010, the number of registered unemployed in labor and welfare divisions in aimags and the capital reached at 36.0 thous, which increased by 3728 persons 11.6 percent compared to the same period of the previous year.

The 19.5 thousand females registered themselves as unemployed, which shares 54.3 percent of total registered unemployed.

As of the first 2 months of 2010, 3.0 thousand registered unemployed persons found jobs, 18.1 percent out of them found jobs in government or state-owned enterprises and remaining 81.9 percent in companies, cooperatives or other types of employers, such as small-scale private businesses.

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2009 оны 4 дүгээр улирлын судалгаанд Улаанбаатар хот, 21 аймгийн нийт 2802 өрх хамрагдлаа.

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 349.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.6 хувиар өсчээ.

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2009 оны 4 дүгээр улирлын байдлаар 368.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.9 хувиар нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалд 2010 оны эхний 2 сард 353.3 мян.хүн хамрагдаж, шимтгэл төлж байгаагийн 208.4 мян.хүн буюу 59.0 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагын, 144.9 мян.хүн буюу 41.0 хувь нь төсөвт байгууллагын даатгуулагчид байна.

Нийгмийн даатгалын сангаас 2010 оны эхний 2 сард нийт 55.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосны 73.0 хувийг өндөр насны, 12.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 7.6 хувийг тэжээгчээ алдсаны, 6.6 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 2010 оны эхний 2 сард 172.7 мянган хүнд олгож, 7.9 тэрбум төг зарцуулжээ.

Улсын хэмжээнд төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 2010 оны эхний 2 сард 11253 болж, өмнөх оны мөн үеийнхээс 983 хүүхдээр буюу 9.6 хувь, амаржсан эх 11219 болж, 991 эхээр буюу 9.7 хувиар нэмэгджээ.

Улсын хэмжээгээр нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 243 болж, өмнөх оны мөн үеийнхээс 25 хүүхдээр буюу 11.5 хувь, 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 64 болж, 33 хүүхдээр нэмэгдэж, харин эхийн эндэгдэл 7 болж, 4 эхээр буурсан байна.

1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2010 оны эхний 2 сарын байдлаар 27 болж өмнөх оны мөн үеийнхээс 3-аар өсчээ.

1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 22 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1-ээр нэмэгдэж, Увс, Ховд, Өвөрхангай, Баян-Өлгий, Архангай, Сүхбаатар, Дорнод

The 2802 households sampled in the HSES for 4th quarter, 2009 from 21 aimags and Ulaanbaatar city.

The household monthly average monetary income reached at 349.1 thous.togrogs and it shows an increase of 1.6 percent compared to the same period of previous year.

As 4th quarter of 2009, the household monthly average monetary expenditure was 368.3 thous.togrogs and it has increased by 0.9 percent compared to the same period of previous year.

As of the first 2 months of 2010, 353.3 thousand persons covered in social insurance and paid contribution, which constitutes 208.4 thousands or 59.0 per cent are insurers from of establishments and enterprises, and 144.9 thousands or 41.0 per cent were insurers of government budget organizations.

Through the social insurance fund, 55.4 bln.tug allocated for pension. 73.0 percent of total allocated pension was for elderly, 12.8 percent was pension for disabled persons, 7.6 percent allocated for breadwinner loss pension and 6.6 percent was pension for military.

In the first 2 months of 2010, 172.7 thousand people received social welfare pensions and benefits, comprising a total sum of 7.9 bln.tug.

In the first 2 months of 2010, the number of live births reached 11 253 and it shows an increase of 983 children or 9.6 percent. The number of mothers delivered child was 11 219 and increased by 991 mothers or 9.7 per cent compared to the same period of the previous year.

In the meantime the number of infant mortality stood at 243 and it is showing an increase of 11.5 per cent or 25 infants, and child mortality under 5 has reaching 64 which is increased by 33 children, while number of maternal deaths reached at 7 and it has showing a decrease of 4 mothers compared to the same period of the previous year.

As of the first 2 months of 2010, the under five mortality per 1000 live births reached at 27 and increased by 3 cases compared to the same period previous year.

The infant mortality rate per 1000 live births was 22 and it increased by 1 case from the same period previous year, and this indicator is higher in Uvs, Khovd,

аймагт улсын дунджаас 8-25-аар илүү байна.

Халдварт өвчнөөр 2010 оны эхний 2 сард 4.9 мян. хүн өвчилж, өмнөх оны мөн үеийнхээс 974 хүн буюу 16.6 хувиар буурсны дотор салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 404 хүн буюу 75.5 хувь, вируст хепатитаар өвчлөгчдийн тоо 405 хүн буюу 29.5 хувь, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 189 хүн буюу 24.6 хувь, цусан суулгаар өвчлөгчдийн тоо 28 хүн буюу 8.2 хувь, трихомониазаар өвчлөгчдийн тоо 91 хүн буюу 12.0 хувь, гонококкт халдвараар өвчлөгчдийн тоо 36 хүн буюу 3.8 хувиар тус тус буурч, харин сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 13 хүн буюу 2.2 хувиар нэмэгдэв.

Манай улсад 2010 оны 2 дугаар сарын байдлаар томуугийн цартахлын А хүрээний (H1N1) вирус халдварын 72 тохиолдол бүртгэгдсэнээс 20 буюу 27.8 хувь нь Улаанбаатар хотод, 52 тохиолдол буюу 72.2 хувь нь хөдөө орон нутагт гарснаас Өвөрхангай аймагт 17 буюу 23.6 хувь, Орхон аймагт 9 буюу 12.5 хувь, Сүхбаатар, Сэлэнгэ аймагт тус тус 5 буюу 6.9 хувь, Дорноговь, Өмнөговь аймагт тус тус 4 буюу 5.6 хувь, Дорнод, Дундговь аймагт тус тус 2 буюу 2.8 хувь, Дархан-Уул, Төв, Ховд, Хөвсгөл аймагт тус тус 1 буюу 1.4 хувь байна. Энэхүү вирус халдвараар 2010 оны 2 дугаар сард Сэлэнгэ аймагт 1 хүн нас бараад байна.

2010 оны эхний 2 сарын байдлаар ХДХВ/ДОХ-ын 2 тохиолдол бүртгэгдэж улсын хэмжээнд нийт ХДХВ/ДОХ-ын 65 тохиолдол бүртгэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2010 оны эхний 2 сард 3.0 мян. хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс 576 хүн буюу 23.9 хувиар өссөн байна.

Эмнэлэгт нийт 111.5 мянган хүн хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 5.9 мянган хүн буюу 5.6 хувиар нэмэгдэв.

Улсын хэмжээнд 2010 оны эхний 2 сард 3175 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 191 хэргээр буюу 5.7 хувиар буурчээ.

Uvurkhangai, Bayan-Ulgii, Arkhangai, Sukhbaatar and Dornod aimags by 8-25 than the national average.

In the first two months 2010, the 4.9 thousand persons suffered by various infectious disease and it shows a decrease of 974 cases or 16.6 percent compared to the same period previous year, which the number of persons infected by chicken pox disease (varicella) decreased by 404 persons or 75.5 percent, viral hepatitis by 405 persons or 29.5 percent, syphilis by 189 persons or 24.6 percent, shigellosis (form of dysentery caused by bacteria) by 28 persons or 8.2 percent, trichomoniasis by 91 persons or 12.0 percent and gonococcus decreased by 36 persons or 3.8 percent respectively. The number of persons suffered by tuberculosis was showing an increase of 2.2 percent or 13 persons.

In the February of 2010, the total number of confirmed cases of a pandemic of a novel strain of the influenza A/H1N1 virus was 72. Of total cases, 20 cases or 27.8 percent recorded in Ulaanbaatar city and 72.2 percent or 52 was in countryside namely, in Uvurkhangai was 17 or 23.6 percent, in Orkhon 9 or 12.5 percent, in Sukhbaatar, Selenge 6.9 percent or 5 respectively. As well as, 4 cases or 5.6 percent recorded in Dornogovi, Umnugovi aimags 2 cases or 2.8 percent in Darkhan-Uul and Dundgobi aimags, and 1 case or 1.4 percent recorded in each of Darkhan-Uul, Tuv, Khovd, Khuvsgul respectively aimags. In February of 2010, 1 case of death caused by this virus recorded in Selenge aimag.

As of the first 2 months of 2010, 2 cases of HIV/AIDS newly recorded and recently total 65 cases of HIV/AIDS have recorded in.

In the first 2 months of 2010, total number of deaths reached at 3.0 thousands and it has showing an increase of 23.9 percent or 576 persons compared to the same period previous year.

Total 111.5 thousand persons hospitalized and it has showing an increase of 5.9 thous. persons or 5.6 percent compared to the same period previous year.

The total number of crimes committed in a first 2 months 2010 estimated at 3175 and it shows a decrease of 191 crimes or 5.7 percent compared with the same period of the previous year.

Зарим төрлийн гэмт хэрэг өссөн ч өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг, аж ахуйн эсрэг гэмт хэрэг 4.9-53.3 хувиар буурсан нь нийт гэмт хэргийн тоо буурахад нөлөөлжээ.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл 38.9 хувь нь гэр, орон сууцанд, 18.0 хувь нь гудамж талбайд, 14.2 хувь нь олон нийтийн газарт, 1.3 хувь нь нийтийн тээвэрт, 2.7 хувь нь төрийн байгууллагад, 2.1 хувь нь төрийн бус байгууллагад, 4.4 хувь нь аж ахуйн нэгжид, 4.5 хувь нь авто зам дээр, 13.9 хувь нь бусад газарт үйлдэгджээ.

However some types of offences were increased, particular crimes such as crime against the right of ownership, crime against environmental protection rules fell, crime against judicial procedure, crime against child, family and social morality and crime against economic entity by 4.9-53.3 per cent has affecting to decline of crime cases.

By location, where crime committed, 38.9 percent of total offences committed in living residence (gers or apartments), 18.0 per cent in the street, 14.2 per cent is in public organizations, 1.3 per cent in public transportation, 2.7 per cent in government agencies, 2.1 per cent in non-government agencies, 4.4 per cent in economic entity, 4.5 per cent in road and 13.9 per cent was committed in other places.

II.Макро эдийн засгийн үзүүлэлт

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮҮИ) 2010 оны 2 дугаар сард өмнөх сартай харьцуулахад 3.0 хувь, өмнөх оны жилийн эцсийнхээс 5.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 8.3 хувиар тус тус өссөн байна.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 3.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 6.2 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Түүнчлэн согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 1.5 хувь, гэр ахуйн тавилга, барааных 1.1 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 0.1 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээнийх 8.4 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 0.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 2.9 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 1.0 хувиар тус тус өсчээ. Харин орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувь, тээврийн бүлгийнх 0.9 хувиар буурч, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ тогтвортой байв.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2010 оны 2 дугаар сард өмнөх сартай харьцуулахад Өмнөговь аймагт 0.2 хувиар буурсан бөгөөд бусад 20 аймаг, Улаанбаатар хотод 0.3-7.7 хувиар өссөн байна.

II. Macro economical indicators

In February 2010, compared with the previous month, the national consumer price index increased by 3.0 percent, by 5.4 percent compared with the end of 2009 year and by 8.3 percent compared with the same period of the previous year, respectively.

The national aggregate index of food and non-alcoholic beverages group increased by 6.2 percent which was major contribution to the increase in the overall index by 3.0 percent, compared with January, 2010. Therefore, the prices of alcoholic beverages and tobacco group increased by 0.3 percent, the prices of clothing, footwear and cloth group by 1.5 percent, the prices of furnishings, household goods group by 1.1 percent, the prices of health group by 0.1 percent, the prices of communication group by 8.4 percent, the prices of recreation and culture group by 0.6 percent, the prices of restaurants and hotels group by 2.9 percent, the prices of miscellaneous goods and service group by 1.0 percent, respectively. But the prices of housing, water, electricity and fuels group decreased by 0.1 percent, the prices of transport group by 0.9 percent, and the prices of education group were stable.

In February 2010, compared with the previous month, the Consumer Price Index went down by 0.2 percent in Umnugobi aimag and in a range of 0.3-7.7 percent rose in remaining 20 aimags and in the capital city Ulaanbaatar.

Монголбанкны мэдээгээр мөнгөний нийлүүлэлт (M2) 2010 оны 2 дугаар сарын эцэст 2960.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сарынхаас 89.0 тэрбум төг буюу 3.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 645.2 тэрбум төг буюу 27.9 хувиар өсчээ.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2010 оны 2 дугаар сарын эцэст 352.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сарынхаас 1.5 тэрбум төг буюу 0.4 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 45.0 тэрбум төг буюу 11.3 хувиар буурчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2010 оны 2 дугаар сарын эцэст 2682.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сарынхаас 7.6 тэрбум төг буюу 0.3 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 3.3 тэрбум төг буюу 0.1 хувиар буурчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2010 оны 2 дугаар сарын эцэст 142.8 тэрбум төгрөгт хүрч, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.3 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх сарынхаас 20.3 тэрбум төг буюу 16.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 0.2 тэрбум төг буюу 0.1 хувиар тус тус өсчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2010 оны 2 дугаар сарын эцэст 442.5 тэрбум төг болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 16.5 хувийг эзэлж байгаа нь өмнөх сарынхаас 15.7 тэрбум төг буюу 3.4 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 243.9 тэрбум төг буюу 2.2 дахин нэмэгдсэн байна.

Үнэт цаасны арилжаа 2010 оны 2 дугаар сард 18 удаа явагдаж, 1.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 3.8 сая ш үнэт цаас арилжигдсан байна.

Арилжигдсан үнэт цаасны тоо өмнөх сарынхаас 2.8 сая ш буюу 3.7 дахин өсч, өмнөх оны мөн үеийнхээс 8.5 сая ш буюу 3.2 дахин буурчээ.

Гүйлгээний хэмжээ өмнөх сарынхаас 1.3 тэрбум төг буюу 3.0 дахин, өмнөх оны мөн үеийнхээс 0.5 тэрбум төг буюу 39.0 хувиар өсчээ.

Улсын нэгдсэн төсвийн орлого, тусламжийн нийт хэмжээ 2010 оны эхний 2 сард 326.7 тэрбум төг, нийт зарлага, эргэж

According to the report of the Bank of Mongolia, at the end of February 2010, the money supply (broad money or M2) expanded to 2960.0 bln.togrogs, which reflects the increase of 89.0 bln.togrogs or 3.1 percent over the previous month, and the increase of 645.2 bln.togrogs or 27.9 percent compared with the same period of the previous year.

At the end of February 2010, currency issued in circulation reached 352.3 bln.togrogs and increased by 1.5 bln.togrogs or 0.4 percent compared with the previous month, and decreased by 45.0 bln.togrogs or 11.3 percent compared with the same period of the previous year.

The loans outstanding at the end of February 2010, amounted to 2682.0 bln.togrogs, and increased by 7.6 bln.togrogs or 0.3 percent compared with the previous month, decreased by 3.3 bln.togrogs or 0.1 percent compared with the same period of 2009.

At the end of February 2010, meanwhile, the principals in arrears increased by 20.3 bln.togrogs or 16.6 percent over the January 2010, reaching 142.8 bln.togrogs which was 5.3 percent of the total loans outstanding, and increased by 0.2 bln.togrogs or 0.1 percent compared with the same period of the previous year.

At the end of February 2010, the non-performing loans reached 442.5 bln.togrogs, which was 16.5 percent of the total loans outstanding, and it went down by 15.7 bln.togrogs or 3.4 percent over the previous month, and increased by 243.9 bln.togrogs or 2.2 times compared with the same period of the previous year.

In February 2010, there were 18 trading days and 3.8 mln.shares traded with the value of 1.9 bln.togrogs.

The number of shares traded rose by 2.8 mln.stocks or 3.7 times compared with the previous month, and decreased by 8.5 mln.stocks or 3.2 times compared with the same period of the previous year.

The value of traded stocks increased by 1.3 bln.togrogs or 3.0 times compared with the previous month, and by 0.5 bln.togrogs or 39.0 percent compared with the same period of the previous year.

In the first 2 months of 2010, the total revenue and grants of the General

төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 378.1 тэрбум төг болж, нийт тэнцэл 51.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Төсвийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 60.8 тэрбум төгрөгөөр буурахад төсвийн орлогын өсөлт зарлагынхаас 53.8 пунктээр их байгаа нь нөлөөлжээ.

Төсвийн урсгал орлого 311.8 тэрбум төг, урсгал зардал 348.4 тэрбум төг болж, урсгал тэнцэл 36.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 119.9 тэрбум төг буюу 74.8 хувиар өсөхөд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 37.0 тэрбум төг буюу 227.4 дахин, аж ахуйн нэгжийн орлогын албан татварынх 33.5 тэрбум төг буюу 2.2 дахин, нэмэгдсэн өртгийн албан татварынх 14.4 тэрбум төг буюу 34.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оны мөн үеийнхээс 15.0 тэрбум төг буюу 91.3 хувиар өсөхөд навигацгийн орлого 5.3 тэрбум төг буюу 5.2 дахин, төсөвт газрын өөрийн орлого 8.6 тэрбум төг буюу 2.0 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2010 оны эхний 2 сард 378.1 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 88.7 тэрбум төг буюу 30.7 хувиар өссөнд татаас, шилжүүлэг 74.6 тэрбум төг буюу 60.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хөрөнгийн зардал 2010 оны эхний 2 сард 23.6 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 6.2 тэрбум төг буюу 35.8 хувиар өсчээ. Хөрөнгийн зардлын өсөлт нь дотоодын эх үүсвэрээс хийгдсэн хөрөнгийн зардал 7.7 тэрбум төг буюу 49.9 хувиар өссөнөөс голлон шалтгаалжээ.

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2009 оны IV улиралд 137.2 сая ам.долларын алдагдалтай гарч өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 156.4 сая ам.доллар буюу 53.3 хувиар буурчээ. Үүнд барааны тэнцлийн алдагдал 15.6 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад

Government budget amounted to 326.7 bln.togrogs and total expenditure and the net lending were 378.1 bln.togrogs representing a deficit of 51.4 bln.togrogs in the General Government budget overall balance.

The lower deficit by 60.8 bln.togrogs against the same period of the previous year was due to total revenue increase, which was by 53.8 point higher than the total expenditure increase.

The current revenue of the General Government budget amounted to 311.8 bln.togrogs and the current expenditure reached 348.4 bln.togrogs. Thus, the budget current balance was in deficit of 36.6 bln.togrogs.

Compared with the same period of the previous year, the tax revenue increased by 119.9 bln.togrogs or 74.8 percent. This was mainly due to increases of 37.0 bln.togrogs or 227.4 times in windfall tax revenue, of 33.5 bln.togrogs or 2.2 times in corporate income tax revenue, and 14.4 bln.togrogs or 34.6 percent in value added tax revenue.

Compared with the same period of the previous year, the non-tax revenue increased by 15.0 bln.togrogs or 91.3 percent. This was mainly due to increase of 5.3 bln.togrogs or 5.2 times in navigation revenue and 8.6 bln.togrogs or 2.0 times in revenues from budget entities.

Compared with the same period of the previous year, the total expenditure and the net lending of the General Government budget reached 378.1 bln.togrogs which is reflecting the increase of 88.7 bln.togrogs and 30.7 percent. This was mainly due to increase of 74.6 bln.togrogs or 60.8 times in subsidies and transfers, in the first 2 months of 2010.

In the first two months of 2010, the spendings of 23.6 bln.togrogs for the capital expenditure rose by 6.2 bln.togrogs or 35.8 percent over the same period of the previous year. Increase in capital expenditure was due to the increase of 7.7 bln.togrogs or 49.9 percent in domestic sources of the capital expenditure.

In the fourth quarter of 2009, the current account deficit of the Balance of Payments equaled to 137.2 mln. US dollars. Compared with the same period of the previous year, the current account deficit decreased by 156.4 mln. US dollars or 53.3 percent. The deficit of the Goods balance reached to 15.6 mln. US dollars, compared

207.6 сая ам. доллар буюу 93.0 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Хөрөнгө ба санхүүгийн данс 2009 оны IV улиралд 363.3 сая ам.долларын ашигтай гарч, 2008 оны мөн үеийнхтэй харьцуулахад 55.0 сая ам.доллар буюу 17.8 хувиар өссөн байна.

2009 оны IV улиралд 284.1 сая ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 157.5 сая ам.доллар буюу 2.2 дахин өсчээ. Үүнд манай улсад оруулсан шууд хөрөнгө оруулалт 184.5 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57.2 сая ам.доллар буюу 1.4 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Манай улс 2010 оны эхний 2 сард дэлхийн 86 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 607.6 сая ам.доллар, үүнээс экспорт 311.7 сая ам.доллар, импорт 295.8 сая ам.долларт хүрчээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 169.4 сая ам.доллар буюу 38.7 хувь, үүний дотор экспортын хэмжээ 79.3 сая ам.доллар буюу 34.1 хувь, импортын хэмжээ 90.0 сая ам.доллар буюу 43.7 хувиар өсчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2010 оны эхний 2 сард 15.9 сая ам.долларын ашигтай гарсан ч, өмнөх оны мөн үеийнхээс 10.6 сая ам.доллар буюу 40.0 хувиар багасав.

